

| | |
|------------------------------|---------------------------------------------------------------------------------|
| 著者(英) | Urianhai L. Terbish, Urianhai T. Chuluun-Erdene |
| journal or publication title | Senri Ethnological Reports |
| volume | 98 |
| page range | iii-viii |
| year | 2011-03-18 |
| URL | http://doi.org/10.15021/00000983 |

Толь хэрэглэгчдийн анхаарал

I. Бичих хэлбэр адил салаа утгатай үгсийг цэгтэй араб тоон дарааллаар жагсаав. Жишээ нь:

ᠠᠨᠠᠭᠠᠨ-1.цагаан шороо 2.оо 3.цав цагаан 4.цагаан будаг

гэх мэт.

II. Үйл үгийн ард тухайн үйл үгийн өнгөрсөн, ирээдүй цаг болон захирах хүсэх хэвийг тавьж, тус бүрийг тусгайлан толгой үг болгов. Үйл үгийн ард тавьсан (ө.ц) нь тухайн үйл үгийн өнгөрсөн цаг, (и.ц) нь ирээдүй цаг, (з.х) нь захирах, хүсэх хэв хэмээсэн тэмдэглэл болно. Жишээ нь:

ᠬᠤᠷᠠᠬᠤ-1.хурах, цугларах 2.ерөнхийлэх, дөхөмчлөх 3.хураах, ᠪᠤᠴᠠᠭ (ө.ц),

ᠠᠨᠠᠭᠠᠨ (и.ц), ᠠᠨᠠᠭᠠᠨ (з.х)

ᠪᠤᠴᠠᠭ (ө.ц) ᠠᠨᠠᠭᠠᠨ Энэ толгой үгийг ᠪᠤᠴᠠᠭ нь ᠠᠨᠠᠭᠠᠨ хэмээх үйл үгийн өнгөрсөн цаг гэж ойлговол зохистой.

ᠠᠨᠠᠭᠠᠨ (и.ц) ᠠᠨᠠᠭᠠᠨ Энэ толгой үгийг ᠠᠨᠠᠭᠠᠨ нь ᠠᠨᠠᠭᠠᠨ хэмээх үйл үгийн ирээдүй цаг гэж ойлговол зохистой.

ᠠᠨᠠᠭᠠᠨ (з.х) ᠠᠨᠠᠭᠠᠨ Энэ толгой үгийг ᠠᠨᠠᠭᠠᠨ нь ᠠᠨᠠᠭᠠᠨ хэмээх үйл үгийн захирах, хүсэх хэв гэж ойлговол зохистой.

гэх мэт.

III. Бичих хэлбэр адил үйл үг, нэр үг хоёрыг тус, тусд нь толгойлж, орчуулгыг жижиг тоогоор өмнө дурдсанчилан жагсаав. Жишээ нь

1. ᠬᠤᠷᠠᠬᠤ-1.хүрэлцэх, барих, атгах 2.тэмтрэх 3.үнэрлэх, ᠮᠠᠨᠠᠭᠠᠨ (ө.ц),

ᠮᠠᠨᠠᠭᠠᠨ (и.ц), ᠮᠠᠨᠠᠭᠠᠨ (з.х)

2. ᠬᠤᠷᠠᠬᠤ-1.эд хогшил, хөрөнгө, эд баялаг 2.эд олзоор ханасан

IY. Төвд хэлний хуучин нэр томъёог монгол хэлний холбогдох хуучин нэр томъёогоор орчуулж, ард нь тайлбар хадав. Жишээ нь:

ᠬᠤᠷᠠᠬᠤ-агсан авах нь бусдаас зоос авч хөлс өгөх

ᠬᠤᠷᠠᠬᠤ-чихээ хатангадах нь чихээ тосон чагнах

ᠮᠠᠨᠠᠭᠠᠨ-газарт унасан нь хүрмэг, хүрмэг нь намар модны навч тэргүүтэн

зулгарч унасан тэр болой.

ᠮᠠᠨᠠᠭᠠᠨ-тавсаг нь авдартай адил бөгөөд нимгэн хавтгай модыг арьсаар бүрж

хийсэн сав.

гэх мэт.

Y. Элдэв нэрийн тоо, газар орон, номт мэргэд, ном дэлгэсэн хаад, хатад, хүрээ хийд, гол шүтээн, судар, дандарын гол шүн, мэдлэг ухааны нэр томъёо зэргийн ард товч тайлбар хийв. Жишээ нь:

དཀར་བཞི་ལ། ཞི་དབྱུང་ལ་འདྲུལ་མཛོད་བཅས་གཞུང་ཚོན་བཞི་དམ་བཅའ་བཞག་པའི་དགོང་ལེས། -**дөрвөн бэрхийг мэдэгч**,
гаашиба нь цаннидын ухааны “Ум”, “Парчин”, “Дүлба”, “Зод” сэлт дөрвөн их
гол шүнгийн дамжаа барьсан гэвш

དཀྱིགས། -**ИНГҮМЭЛ** нь арван долоон бинттэй тоо бөгөөд хуучин тооны хэлээр арвыг нэг
бинттэй, зууг хоёр бинттэй гэх бөгөөд одоогийн математикийн нэр томъёогоор бол
бинттэй гэдэг нь арвын зэрэгтэй хэмээсэн утга агаад ингүмэл нь арвын арван долоон
зэрэгт тоо болох амуй.

ཀར་ཚུང་རྩེས། -**цасан чихрийн амт мэт зурхай** нь Балбын мэргэдийн боловсруулсан
жилийн үр тариа, хур, өвс, салхи, чийг, халуун, хүйтэн, арвидал, хомсдол
тэргүүтнийг тоон утгаар илэрхийлэн бодох зурхайн арга. Газар, газрын мэргэд
тухайн аргыг өөрийн нутгийн хуваарьт тохируулан саалт хийж, зурхайн гол
шүндээ оруулсан байдаг.

རྒྱུང་ཞག། -**турлиахны хоног** нь наран од хорин дөрвөн, мөч дөчин дөрөвд хүрэхүй
хоног бөгөөд түүнээс хойш есөн хоног тоолж, тэнгэрийг шинжих ба энэ үед хур
орвоос тэнгэр хүйтэрч ган болно хэмээдэг

རྟུང་ལྷ། -**хуанли** нь Хятадын шар зурхайн цаглабар хуучин ханз бичиг хэрэглэж
байсан улс орнуудад дэлгэрсэн бөгөөд Манж Чин улсын үед Тэнгэрийг сүсэглэх
яаман гэдгээс хэдэн мянган хувиар барлаж, Монгол, Төвд тэргүүтэн харьяа
колони орнууддаа хүчээр хэрэглүүлж байсан түүхтэй. Өөр, өөрийн нь хэл
бичгээр тархаасан эл хуанлийг манай орны учир үл мэдэх заримууд
“Чингисийн шар зурхайн монгол тоолол” гэж гүжирдэх нь тахиан харалган
сохор таван өнгийн солонгийн гэрлийг дурайтал харагч нүдтэн лүгээ “Би
чамаас илүү хардаг” хэмээн бухимдан маргах лугаа агаар нэгэн.
гэх мэт.

YI. Илт өгүүлэх нэрийн ард үгчилсэн орчуулгыг тавьж, ёгт утгыг жижиг үсгээр
хавсаргав. Жишээ нь:

ལྷན་བྱེད་རྒྱལ་པོ། -**бүхнийг үйлдэгч хаан** нь 1.сэтгэл мэдрэл 2.хоосон чанар 3.Эсүрва
тэнгэр

རྒྱལ་བུ་ལྷ་མཚོ། -**төрөлхтөний манлай** нь бурхан

ལྷ་འོག་ཞག། -**тэнгэрийн орон** нь 1.Сүмбэр уул 2.судрын хуудасны дээд талын
хоосон зай

རྣམ་པའི་ཚོར་ལ། -**чихний өргөс** нь бүдүүлэг үг
гэх мэт.

YII. Утга адил атал бичих хэлбэр өөр үгсийг нэгийн нь ард орчуулгыг хадаад,
бусдыг нь ард тэнцүүгийн тэмдэг (=) тавьж орчуулгыг хадсан үгийг тавив.
Ийнхүү тэнцүүгийн тэмдэг хэрэглэсэн нь нэгдүгээрт ухахад хялбар,
хоёрдугаарт зай бага эзлүүлэе хэмээснээс болсон хэрэг. Жишээ нь:

རྒྱ་ལྷི་བ། = རྒྱ་རི་བ།

ཚང་ལན་ཚུ་འཇུག། -архины хариуд ус өгөх нь сайныг муугаар хариулахын

зүйрлэл, бас ачийг бачаар гэж орчуулж болно.

ཐུགས་སྒྲུབ་གང་དུ་གནང། -тааллын үзэгдэл алин дуртгаснаа айлдах нь дур зоргоороо

аашлахын зүйрлэл, дураараа дургиж, дунд чөмгөөрөө жиргэх гэж орчуулж болно.

བཀའ་མཛོད་ལྟོབས། -бухын хэвтэртээ, хайнагийн гүзээтэй нь хашин хойрго,

хамгийг идэгчийн зүйрлэл, ууж идэх нь уургын морь, урагшаа хөдлөх нь ургаа хад гэж орчуулж болмоор гэх мэт.

Толь бичгийг зохиох үест ном дэвтрээр тусалсан нийт хүмүүс, нэн ялангуяа эрхэм нэгэн номын нөхөр толь зүйч доктор, профессор н.Гантогтох, Япон Улсын Кёто хотын Оотанигийн Их Сургуулийн профессор Такаши Мацукава болон алдаа мадагийг засах зэрэгт гар бие оролцсон хайрт охин Т.Юмжирдулам, эрхэм шавь Ц.Нямжанцан нартаа талархлын үг өргөө.

Энэ толь бичгийг тэрлэх үед үнэт зөвлөгөө өгөхийн ялдраа алдаа, мадагийг ариутган шүүсэн Монгол Улсын Шинжлэх Ухааны Гавъяат Зүтгэлтэн доктор(ScD), профессор Хотгойд Лхамсүрэнгийн Хүрэлбаатар агснаа гүнээ талархалтай байдгаа илэрхийлэхийн ялдраа түүний хамтран зүтгэгч, шавь нар, үр хүүхдэд нь судалгааны шинжилгээний өндөр амжилт хүсье.

Долоон түм гаруй толгой үгтэй, олон зуун тайлбартай эл толь бичиг “Уншигч абугай нарт өчүүхэн ч атугай туслах болов уу?” хэмээн эгээрнэм.

Эцэст нь энэхүү толь бичгийг ивээн тэтгэж “Senri Ethnological Reports” нэрт судалгаа, шинжилгээний алдартай цувралдаа хэлхэн хэвлүүлсэн Япон Улсын Осака хотын Угсаатны зүйн Үндэсний Музейн хамт олон болон профессор Яасухико Нагано, нэн ялангуяа эрхэм профессор Юүки Конагая абугайд чин талархлаа илэрхийлж, Та бүхний судалгаа шинжилгээний бүтээл дэлхийн цэцэг мэт дээш, дээш дэлгэрч байхын елзийтэй ерөөлийг дэвшүүлж, эл хэдэн нуршаа үгээ төгсгөсүгэй!

Гэм, алдал болсон бүхнийг гэгээн мэргэд хүлцэн болгоож, үнэт сургамжит үгсийг хайрлах ажаамуу.

Зохиогч:

Түүхийн шинжлэх ухааны доктор(ScD)

Урианхай Лхасрангийн Тэрбиш

Боловсрол судлалын доктор(PhD)

Урианхай Тэрбишийн Чулуун-Эрдэнэ

XVII жарны “Тийн урвагч” хэмээх
Төмөр Барс жилийн Хаврын тэргүүн
Шар Барс сарын Шинийн Найман